



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 22 өдөр

Дугаар А/129

Номгон

Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын
үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "г", Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 8 дугаар зүйлийн 8.1.1, Засгийн газрын 2015 оны 11 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дүрэм"-ийн 7 дугаар зүйлийн 7.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Г.Энхбаяр-Аймгийн Засаг даргын орлогч

Нарийн бичгийн дарга: Д.Энхжаргал- Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Гишүүд: М.Должинсүрэн-Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн мэргэжилтэн

П.Болормаа-Нийгмийн даатгалын хэлтсийн Хяналт шалгалт, дотоод аудитын тасгийн дарга

Т.Ерэнбаяр-Эрүүгийн ахлах мөрдөгч, Цагдаагийн ахмад

С.Батцэцэг-Эрүүл мэндийн газрын хяналт шинжилгээ үнэлгээ, мэдээллийн хэлтсийн дарга

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний төлөөлөл /зөвшилцсөнөөр/


2.Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх удирдамжийг хавсралтаар баталсугай.

3.Хяналт шалгалт хийсэн тайлан, дүгнэлтийг 2021 оны 03 дугаар сарын 10-ны дотор Засаг даргын зөвлөлд танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Г.Энхбаяр/-т үүрэг болгосугай.


1210327

2.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /М.Өнөржаргал/-д даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

Аймгийн Засаг даргын 2021 оны 02 дугаар
сарын 22-ны өдрийн АИ 29 дүгээр
захирамжийн хэвсрэлт



**ЭМНЭЛЭГ ХӨДӨЛМӨРИЙН МАГАДЛАХ КОМИССЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ ШАЛГАЛТ
ХИЙХ АЖЛЫН УДИРДАМЖ**

Нэг. Үндэслэл

Тус аймгийн Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын үйл ажиллагаа болон магадлагч эмчийн талаар иргэд, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэгдсэн төв ТББ-аас ирүүлсэн гомдол, мэдээлэл, хүсэлтийн дагуу хяналт шалгалтыг хийх

Хоёр. Зорилго

Аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх Эмнэлэг хөдөлмөрийн магадлах орон нутгийн комисс нь үйл ажиллагаандаа Нийгмийн даатгалын тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль, Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль болон энэхүү дүрэм, нийгмийн хамгаалал, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан эрх зүйн актыг тус тус мөрдөн ажиллаж буй эсэхэд хяналт тавихад оршино.

Гурав. Хяналт шалгалт хийх хугацаа

1.Хяналт шалгалтыг 2021 оны 02 дугаар сарын 22-ны өдрөөс 03 дугаар сарын 08-ны өдрүүдэд захирамжаар батлагдсан ажлын хэсэг хийнэ.

2.Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын 2016-2020 оны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх

Дөрөв. Хяналт шалгалтын хамрах хүрээ /үзүүлэлт/

4.1.Иргэний хөдөлмөрийн чадвараа алдсан шалтгаан, түүний хувь хэмжээг тогтоох, хугацааг сунгах, цуцлах, хөдөлмөрийн нөхцөлийг өөрчлөх, ажлын цагийг богиносгох асуудлыг эрүүл мэндийн байгууллагын Эмнэлэг хяналтын комиссын шийдвэрийг үндэслэн тогтоосон нотлох баримт шаардлага хангасан, зохих дүрэм, журмын дагуу шийдвэрлэгдсэн эсэх.

2.

4.2. Хөдөлмөрийн нөхцөл нь биеийн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж, өвчин эмгэг нь даамжран, цаашид хүндрэх төлөвтэй иргэний хөдөлмөрийн нөхцөлийг эхний удаа 6 сар хүртэл хугацаагаар өөрчлөх, шаардлагатай тохиолдолд хөдөлмөрийн нөхцөлийг бүрмөсөн өөрчлөх шийдвэр гарсан иргэдийн нотлох баримт шаардлага хангасан, зохих дүрэм, журмын дагуу шийдвэрлэгдсэн эсэх

4.3. Орон нутгийн хөдөлмөрийн чадвараа алдсан иргэний мэдээллийн цахим санг бүрдүүлж, тухай бүр шинэчлэх, хөдөлмөрийн чадвар алдалтын байдалд судалгаа хийх, дүгнэлт гаргах, мэдээллийн хадгалалт, хамгаалалт, нууцлалын найдвартай байдлыг хангасан эсэх

4.4. Орон нутгийн иргэний бүртгэлийн байгууллагатай хамтран хөдөлмөрийн чадвараа алдсан иргэдийн шилжилт хөдөлгөөн, нас баралтын мэдээллийг жил бүр тулган нягтлаж ажилласан эсэх /Улсын бүртгэлийн хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтсийн мэдээг тулгах, хянах/

4.5. Орон нутгийн комиссын үйл ажиллагааны тайлан, мэдээг заасан хугацаанд нь Төв комисст цахим болон цаасан хэлбэрээр хүргүүлж ажилласан эсэх /архивын нэгж бүрдүүлсэн эсэх/

4.6. Төв комиссоос өгсөн үүрэг, даалгаврын биелэлт хугацаандаа явсан эсэх орон нутгийн комиссын үйл ажиллагааны зардал, хөрөнгө оруулалтын зарцуулалтыг хянах /Нийгмийн даатгалын хэлтэст ирсэн бичгийг хянах/

4.7. Орон нутгийн комиссын гишүүдийн томилгоо шаардлага хангаж, сонгон шалгаруулалтын дагуу явагдсан эсэх /томилгооны шийдвэрийг хянах/

4.8. Эмнэлэг хөдөлмөрийн магадлах үйл ажиллагаанд алдаа, дутагдал гаргасан, төрийн албан хаагчийн болон эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн комиссын дарга, гишүүн, албан хаагчдад хариуцлага хүлээлгэх талаар холбогдох байгууллагуудад санал, хүсэлт, гомдол ирсэн эсэх түүний дагуу шийдвэрлэсэн байдал /Эрүүл мэндийн газар, Нийгмийн даатгалын хэлтэст ирсэн өргөдөл, гомдол хүсэлтийг хянах/

4.9. Иргэн хөдөлмөрийн чадвар алдахаас урьдчилан сэргийлэх, сэргээн засах үйл ажиллагааг дэмжих, энэ чиглэлээр сургалт, сурталчилгаа зохион байгуулах, хөдөлмөрийн чадвар алдалтын байдалд судалгаа, шинжилгээ хийж, харилцан туршлага солилцсон ажил, арга хэмжээг хянах..

4.10. Орон нутгийн комисс нь Аймгийн Засаг дарга болон орон нутгийн холбогдох дээд шатны эрх бүхий байгууллагад тайлангаа хэлэлцүүлсэн эсэх

/комиссын 2018-2020 оны жил бүрийн тайланг хэлэлцүүлсэн хурлын тэмдэглэл, тайлантай эсэх/

4.11.Эрүүл мэндийн байгууллага нь Эмнэлгийн байгууллагын Эмнэлэг хяналтын комисс болон Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажилласан эсэх /ажил, арга хэмжээний нотлох баримт материалтай танилцах/

4.12.Орон нутгийн комисс, салбар комиссын дарга, гишүүнд олгосон урамшууллыг хянах / урамшуулал олгосон шийдвэр, хурлын ирц бүртгэл нотлох баримт/

4.13.Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын хурал нь Ковид-19 цар тахлын үед сумдад цахимаар хуралдсан нотлох /видео бичлэг/ баримтыг хянах, хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоосон иргэдэд хяналт тавих

4.14.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэгдсэн төв ТББ-аас ирүүлсэн дараах “2020 оны 10 дугаар сараас хойш эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын магадлагч эмч Т.Цэрэннадмид нь албан үүргээ зохих ёсоор биелүүлэхгүй байгаагаас иргэд нийгмийн халамжийн мөнгөндөө хамрагдаж чадахгүй 2-3 сараар хохирч байна. Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын шийдвэр тухайн өдөртөө баталгаажиж гарын үсэг зурагдсанаар хүчинтэй болдог байхад хэдийд яаж албажаад байгаа нь тодорхойгүй байсаар байна” гэсэн хүсэлтийн дагуу нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгаа иргэдийн судалгааг гаргуулан шалгах, Магадлагч эмчийн албан үүргээ гүйцэтгэж буйд хяналт тавих /цагийн бүртгэл, мэдээ тайлан хугацаанд хүргүүлсэн байдал, хурлын шийдвэр хугацаандаа баталгаажсан эсэх/

Тав. Дүгнэлт

1.Ажлын хэсгийн хяналт шалгалт хийсэн тухай тайланг 2021 оны 03 дугаар сарын 15-ны дотор Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулна.

2.Ажлын хэсэг хяналт шалгалт хийсэн талаар Зөвлөмжийг холбогдох газруудад хүргүүлсэн байна.

3.Хяналт шалгалт хийх явцад илэрсэн зөрчил дутагдлын талаар тухай байгууллагат шаардлагатай бол хугацаатай үүрэг даалгавар өгч ажиллана.

4.Ноцтой зөрчил илэрсэн гэж үзвэл хуулийн дагуу хариуцлага тооцон ажиллана.